

Э-Сонин

32 дахь дугаар

Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

"БИНСЭ" ХК МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 4989 УДААГИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ



SHARYN GOL JSC

"ШАРЫН ГОЛ" ХК БНСУ-РУУ БАЯЖУУЛСАН НҮҮРС ЭКСПОРТЛОХООР БОЛЖЭЭ

ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ АРГА ХЭМЖЭЭ ЦААШИД ҮРГЭЛЖИЛНЭ



АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМТАЙ ХАМТАРЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛНЭ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 5000 ДАХЬ АРИЛЖАА



"ІРО БОЛОН ДАВХАР БҮРТГЭЛ" СЭДЭВТ СЕМИНАР БОЛЛО

"MONGOLIA BUSINESS SUMMIT 2015"-Д ОРОЛЦЛОО



Д.АНГАР: ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛЭЭС 10 ИХ НАЯД ТӨГРӨГ БОСГОХ БОЛОМЖТОЙ

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 6 дугаар сарын арилжааны мэдээлэл.
- "Бинсэ" ХК-ны төлөөлөгч нар МХБ-ийн 4989 дахь арилжааг нээж хонх цохив.
- Шарын Гол ХК нь нүүрсний угаах үйлдвэрээ ашиглалтанд оруулж мөн БНСУ-руу баяжуулсан нүүрсээ экспортлохоор болжээ.
- Олон нийтэд зориулсан хөрөнгийн зах зээлийн Нээлттэй Хаалганы өдөрлөг Эрдэнэт хотод амжилттай зохион байгуулагдав.
- МХБ-ийн төлөөлөгч нар Аж үйлдвэрийн яамны төлөөлөгч нартай уулзалт зохион байгуулж үйлдвэрлэлийн төслүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжүүлэх талаар ярилцав.
- МХБ-ийн 5,000 дахь арилжаа явагдлаа.
- МХБ-ийн гүйцэтгэх захирал Д.Ангар "MONGOLIA BUSINESS SUMMIT 2015"-д оролцлоо.
- Д.Ангар: Хөрөнгийн зах зээлээс 10 их наяд төгрөг босгох боломжтой.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 6-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

"Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох" сургалт"-ыг 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдөр явуулахаар төлөвлөж байна.


Дэлгэрэнгүй мэдээллийг 11323715 -116 дугаараас авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Лхагва гарагаас дараа долоо хоногийн Мягмар гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Тавдугаар сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 5 удаа зохион байгуулж нийт 91.6 тэрбум төгрөгийн богино хугацаат ЗГҮЦ-ыг арилжаалсан байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2015.06.02	ЗГХБ-Б-12-310	12	300,000	14.758%	29,014,500,000.00
2015.06.09	ЗГХБ-Б-28-312	28	150,000	15.020%	13,880,400,000.00
2015.06.16	ЗГХБ-Б-12-314	12	300,000	14.674%	29,019,900,000.00
2015.06.23	ЗГЭБ-Б-52-315	52	100,000	15.473%	10,000,000,000.00
2015.06.30	ЗГЭБ-Б-12-317	12	99,990	14.415%	9,667,932,110.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ			949,990		91,592,732,110.00



"БИНСЭ" ХК МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 4989 УДААГИЙН АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

БИНСЭ

МАЛЫН ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ТӨВ

МХБ-д бүртгэлтэй "Бинсэ" ХК-ийн нэмж гаргаж буй 1,000,000 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг тохиолдуулж 2015 оны 6 дугаар сарын 2-ны өдөр тус компанийн ТУЗ-ийн дарга Г.Цогтбаяр, Гүйцэтгэх захирал Б.Батзаяа нар "Цан" цохин МХБ-ийн 4989 дэх удаагийн үнэт цаасны арилжааг нээлээ.

"Бинсэ" ХК-ийн нэмж гаргаж буй хувьцаа нэг бүрийг нь 744 төгрөгөөр олон нийтэд санал болгож байгаа юм. Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2015 оны 6 дугаар сарын 3-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан байна.

Уг үнэт цаасыг худалдан авахыг сонирхсон хөрөнгө оруулагчид захиалгыг Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан өгч болно.



ШАРЫНГОЛ ХК-ИЙН ХЯНАЛТЫН БАГЦЫГ ЭЗЭМШИГЧ НЬ СИНГАПУРЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД (“SGX”) БҮРТГЭЛТЭЙ ЭРАТАТ ЛАЙФСТАЙЛС ЛИМИТЭД КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН СТАТУСЫГ ШИЛЖҮҮЛЭН АВАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

"Шарынгол" ХК (MSE: SHG) –ийн хяналтын багцыг эзэмшигч АНУ-ын Нью Йорк хотод төвтэй Файрбөрд Менежмент ХХК-ийн удирдаж буй салбар компаниудын төлөөлөлийн мэдэгдсэнээр Монгол Улсад байрлалтай нүүрсний ордууд дахь хувийг эзэмших зорилгоор Сингапур Улсад үүсгэн байгуулагдсан Могул Коул Холдингс компани нь Сингапурын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй бөгөөд шүүхээс томилогдсон хэрэг гүйцэтгэгчийн хяналтад буй Эратат Лайфстайлс Лимитэд компанитай Гүйцэтгэлийн гэрээг байгууллаа. Уг Гүйцэтгэлийн гэрээгээр Могул Коул Холдингс нь Эратат Лайфстайлс Лимитедийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий нэхэмжлэгчдэд өөрийн энгийн хувьцааг гаргаж эзэмшүүлэх, Эратат Лайфстайлс Лимитед нь Сингапурын Хөрөнгийн Бирж дээрх өөрийн бүртгэлийн статусыг Могул Коул Холдингсд шилжүүлэх юм.

Гүйцэтгэлийн гэрээ амжилттай хэрэгжснээр Могул Коул Холдингс компани Сингапурын Хөрөнгийн Биржийн Каталист бүртгэлийн самбарт ("Каталист самбар") бүртгэгдэх ба "Шарынгол" ХК нь түүний шууд бус охин компани болох юм. Гүйцэтгэлийн гэрээ нь хэд хэдэн урьдчилсан нөхцлүүдийг хангасан тохиолдолд бүрэн хэрэгжих бөгөөд уг гэрээ хэрэгжснээр үнэт цаас гаргагчийн хяналтын багц шилжихгүй буюу Файрбөрд Менежмент нь Могул Коул Холдингс компанийн хяналтын багцыг эзэмшиж байгаа тул "Шарын гол" ХК-ийн хяналтын багцад ямар нэгэн өөрчлөлт орохгүй хэвээр үлдэж байгаа болно.

"Шарынгол" ХК нь Монголын Хөрөнгийн Биржид ("MSE") бүртгэлтэй хувьцаат компани хэвээр үлдэнэ. Могул Коул Холдингс компани Каталист самбарт бүртгэгдсэнээр уг биржид бүртгэгдсэн Монгол Улсын уул уурхайн салбарын анхны компани болох ба энэ нь "Шарынгол" ХК-нд өөрийн толгой компанийн Каталист самбар дахь бүртгэлээр дамжин шинэ хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Шарын голын уурхай нь Улаанбаатар хотоос хойд зүгт 215км, Дархан хотоос зүүн урагш 45км зайд төмөр замын үндсэн шугам дагуу байрлалтай ба сайн чанарын нүүрсийг төрийн өмчит ДЦС-ууд, дотоодын цемент үйлдвэрлэгчид болон бусад хэрэглэгч нарт борлуулдаг. 1993 онд Монголын Хөрөнгийн Биржид (MSE: SHG) бүртгэгдсэн ба 2003 онд бүрэн хувьчлагдсан.



SHARYN GOL JSC

"ШАРЫН ГОЛ" ХК БНСУ-РУУ БАЯЖУУЛСАН НҮҮРС ЭКСПОРТЛОХООР БОЛЖЭЭ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Шарын гол" ХК нь (MSE:SHG) Дархан-Уул аймгийн Шарын гол суманд байрлах өөрийн олборлолт явагдаж буй нүүрсний уурхайн дэргэд шинэ нүүрс баяжуулах үйлдвэрээ ашиглалтанд оруулж нээлтээ хийлээ. Энэхүү үйлдвэр нь жилд 600,000 тонн түүхий нүүрс угаах хүчин чадалтай ба ингэсэнээр Шарын гол ХК нь экспортын чанарын шаардлагат нийцсэн нүүрс мөн дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд өндөр зэрэглэлийн чанартай нүүрс болон нүүрсэн бүтээгдэхүүн боловсруулан нийлүүлэх боломжтой болж байна. Энэхүү нүүрс баяжуулах үйлдвэр нь Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй хоёр дахь нүүрс баяжуулах үйлдвэр болж байгаа бөгөөд дотоодын зах зээлд баяжуулсан нүүрс нийлүүлэх зорилготой цорын ганц нүүрс баяжуулах үйлдвэр юм. Энэхүү үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар Шарын голын уурхай нь байгаль орчинд ээлтэй нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой ажиллаж байна.

2015 оны 6-р сарын 19-нд "Шарын гол" ХК нь Монгол улсын засгийн газар болон Өмнөд Солонгос улсын "Саммок Шиппинг" компанийн хоорондын хамтарсан компани болох "Монгол Саммок Ложистикс" ХХК-тай ойлголцлын санамж бичгийг Монголын Бизнес эрхлэгчдийн дээд түвшний уулзалтын үеэр Их Тэнгэр цогцолборт зурлаа. Монгол улсын ерөнхийлөгч ноён Ц.Элбэгдорж ба бусад өндөр хэргэм зэрэгтэй эрхэмүүд Санамж бичигт гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагааны үеэр байлцлаа.



ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ АРГА ХЭМЖЭЭ ЦААШИД ҮРГЭЛЖИЛНЭ



Монголын хөрөнгийн бирж Орхон аймгийн засаг даргын тамгын газартай хамтран “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” арга хэмжээг 6 дугаар сарын 3 өдөр амжилттай зохион байгууллаа.

Нээлттэй өдөрлөгийн хүрээнд: Иргэдийн дунд хүлээлт үүсгээд байгаа Эрдэнэс таван толгой ХК-ийн 1072 хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх асуудлаарх мэдээлэл өгч, ягаан цэнхэр тасалбартай холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, арилжааны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэрэг үйлчилгээг үзүүллээ.

Түүнчлэн аж ахуйн нэгжүүдэд зориулан хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох боломж, Засгийн газрын үнэт цаас худалдан авах замаар богино хугацаат хөрөнгө оруулалт хийж, үндсэн үйл ажиллагаанаас гадуур хүүгийн нэмэлт орлого олох талаар танилцуулга хийсэн бөгөөд Орон нутгийн бонд гаргах боломж талаар Засаг даргын тамгын газарт танилцуулга хийж цаашид мэргэжлийн туслалцаа дэмжлэг өгч хамтран ажиллахаар боллоо.



АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМТАЙ ХАМТАРЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛНЭ



МХБ, Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудтай хамтран бизнес эрхлэгчдийг Хөрөнгийн зах зээлд гаргах олон ажлуудыг зохион байгуулж байгаа билээ.

Өнгөрсөн хугацаанд бизнес эрхлэгчдэд Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, үнэт цаас гаргах тухай мэргэжлийн зөвлөмж өгөх зорилго бүхий сургалт семинарыг зохион байгуулж, үнэт цаас гаргах сонирхол бүхий компаниудыг МХБ-ийн гишүүн андеррайтерийн компаниудтай холбож, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг эхлүүлээд байгаа юм.

6 дугаар сарын 5-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Д.Ангар Аж үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүүтэй уулзаж, санал дэвшүүллээ.

Уулзалтын үеэр Монголын хөрөнгийн бирж өөрийн хэрэгжүүлж буй бодлого чиглэл, хөрөнгийн зах зээл дээрх боломжийг танилцуулсан бөгөөд хамтарсан ажлын хэсэг байгуулж, аж үйлдвэрийн төслүүдийг санхүүжүүлэх боломжийн талаар нарийвчилсан судалгааг хийхээр боллоо.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



2015 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Хонг Конг-д төвтэй олон улсын хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "QUAM Financial Services Group"-ийн ТУЗ-ын дарга Бернад Поулиот Монголын хөрөнгийн биржид зочиллоо.

Уулзалтын үеэр Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар Монголын хөрөнгийн биржээс явуулж буй бодлого, үйл ажиллагаа, засгийн газрын үнэт цаасны арилжаа, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл өгсөн бол, "QUAM Financial Services Group" ТУЗ-ын дарга Бернад

Поулиот манай хөрөнгийн зах зээл дээрх хөрөнгө оруулах боломжууд, ялангуяа ЗГҮЦ-ны талаар мэдээлэл авч хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгаагаа илэрхийллээ.

2015 он гарснаас хойш ЗГҮЦ-нд хөрөнгө оруулах сонирхолтой гадаадын аж ахуй нэгжүүд нэмэгдсээр байна.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

ШАЛГАЛТЫН ТАЙЛАНГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ШИЛЖҮҮЛЛЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн багцын арилжаагаар “Бишрэлт индастриал” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 7.62%-ийг хаалтын ханшнаас 62.16%-ийн ханшийн бууралттай үнээр, “Монгол мах экспо” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 15.04%-ийг хаалтын ханшнаас 48.39%-ийн ханшийн бууралттай үнээр тус тус арилжсан тул холбогдох хэлцэлд шалгалт хийн, шалгалтын тайланг дүгнэлтийн хамтаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 74.1-д заасан чиг үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд шилжүүллээ.

"МОНГОЛЫН ГЭГЭЭ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООЛОО

Санхүүгийн зохицуулах хороонд "Монголын гэгээ" ХК-иас компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарган үнэт цаасны бүртгэлээс хасуулах тухай хүсэлт хүргүүлсний дагуу тус компанийн үнэт цаасны арилжааг 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн зогсоохыг Санхүүгийн зохицуулах хорооноос мэдэгдлээ.

"СИЛИКАТ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООЛОО

Санхүүгийн зохицуулах хороонд "Силикат" ХК-иас компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарган үнэт цаасны бүртгэлээс хасуулах тухай хүсэлт хүргүүлсний дагуу тус компанийн үнэт цаасны арилжааг 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн зогсоохыг Санхүүгийн зохицуулах хорооноос мэдэгдлээ.

“БАЯНБОГД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 162 тоот тогтоол, Монголын Хөрөнгийн биржийн Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт, “Баянбогд” ХК-ийн 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 5/02 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан, Захирлын зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн санал дүгнэлтийг үндэслэн “Баянбогд” ХК-ийн гаргасан нийт 97,607 ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Стандарт проперти групп” ХХК-ийн хөрөнгөнд ногдох 1,530,200 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн хувьцааны тоог 1,627,807 ширхэг болгож, компанийн оноосон нэрийг “Стандарт проперти групп” ХК болгон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа.

ТАВАН ТОЛГОЙ ТЭРГҮҮТЭЙ ХК-ИУД КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани нь СЗХ-ны 2014 оны 162 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан ил тод, нээлттэй, эрх тэгш, хяналттай, хариуцлагатай сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн ажиллаж, нийтэд тайлагнаж байх шаардлагатай байдаг.

Хувьцаат компани нь үйл ажиллагаандаа засаглалын зарчмыг хэвшүүлэн өөрийн засаглалын төвшинг үнэлж, түүний хэрэгжилтэд зохицуулах эрх бүхий байгууллагын зүгээс хяналт тавин, заавар зөвлөгөө өгч, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байх нь цаашид үнэт цаас гаргагчдын хөрөнгө оруулалт татах чадварыг дээшлүүлэхээс гадна нэр хүнд, цар хүрээгээ тэлэхэд төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр болох юм.

Монголын хөрөнгийн бирж, Компанийн засаглалын үндэсний зөвлөл болон ТОП-20 индексийг бүрдүүлэгч "Таван толгой", "Гермес центр", "Материал импекс" болон "Мах импекс" хувьцаат компаниуд Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах "ТУНХАГ БИЧИГ"-т гурвалсан гарын үсэг зурж баталгаажуулаа.

Энэхүү арга хэмжээнд "Гермес центр" ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн, "Материал импекс" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Зориг, "Мах импекс" ХК-ийн ТУЗ-ийн дарга Ж.Чинзориг мөн "Таван толгой" ХК-ийн төлөөлөгчийн газрын дарга Д.Ганболд нар оролцов.



КАСТОИАНЫ ЭЭЛЖИТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Кастодианы үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлэхтэй холбогдуулж Монголын хөрөнгийн бирж нь Лондонгийн хөрөнгийн бирж /ЛХБ/ болон ЛХБ-ийн охин компани болох ЭМАЙТи групптэй хамтран Кастодианы цуврал сургалтыг зохион байгуулж байгаа юм.

2015 оны 6-р сарын 12-нд кастодианы ээлжит сургалт МХБ-ийн байранд зохион байгуулагдсан ба уг сургалтад МХБ, Банк /кастодианы эрх авсан банкууд/, ҮЦТТТХТ, СЗХ зэрэг байгууллагын мэргэжилтэнүүд Шириланка улсын ЭМАЙТи группын мэргэжилтэнтэй онлайнаар холбогдож оролцов. Сургалтаар кастодиан үйлчилгээг ЭМАЙТи системд хэрхэн бүртгэх, Кастодиан банкны бүртгэл мөн арилжаанд хэрхэн оролцох талаар мэдлэг олголоо.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 5000 ДАХЬ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж нь 1991.01.18-ны өдөр байгуулагдаж, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 1995.08.28-ны өдөр эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 4999 удаагийн арилжааг зохион байгуулж, нийт 1.4 их наяд төгрөгийн гүйлгээг хийсэн байна. Өнөөдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 237 хувьцаат компани байгаа бөгөөд зах зээлийн үнэлгээ 1,436,928,399,304 төгрөгт хүрсэн байна.

2015 оны эхнээс өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 270.01 тэрбум төгрөгийн арилжааг хийж өдрийн гүйлгээний үнийн дүн 2.4 тэрбум төгрөгт хүрлээ

“ІРО БОЛОН ДАВХАР БҮРТГЭЛ” СЭДЭВТ СЕМИНАР БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо, Японы олон улсын хамтын ажиллагааны байгуулага болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран Монголын хөрөнгийн зах зээлийн чадавхийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд “ІРО болон давхар бүртгэл” сэдэвт семинар 2015 оны 6 дугаар 23-ны өдөр зохион байгуулагдлаа.

Монголын хөрөнгийн бирж тус семинарт оролцож ТОП-100 аж ахуйн нэгжийн төлөөлөлд “Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх” нь сэдвээр илтгэл тавьж хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө босгох боломжуудын талаар танилцууллаа.



БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ХАМТРАН АЖИЛЛАНА

Барилга хот байгуулалтын яамны сайд Д.Цогтбаатар 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр 10:00 цагт Монголын хөрөнгийн биржийн 5005 дахь удаагийн үнэт цаасны арилжааг “Цан” цохин нээлээ. Уг ёслолын үйл ажиллагаагаар Монголын хөрөнгийн бирж, Барилга хот байгуулалтын яам болон Монголын барилгын үндэсний ассоциаци хамтран ажиллахаа мэдэгдэж, харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Санамж бичиг байгуулснаар Барилгын салбарын компаниуд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох боломжийг нээх юм. Санамж бичгийн хүрээнд дараах ажлууд хийгдэнэ.

Үүнд:

1. IPO буюу олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар хөрөнгийн зах зээлээс урт хугацаат санхүүжилт татах – Банкны зээлийн хүү өндөр, барьцаа батлан даалт шаарддаг, богино хугацаат санхүүжилт олгодог энэ үед хөрөнгийн зах зээлийг ашиглах,
2. Компанийн бонд гаргах – Хөрөнгийн зах зээлд өрийн бичиг гаргаж санхүүжилт татан төвлөрүүлэх, Даатгалын салбарыг компанийн бондод оруулж ирүүлснээр хөрөнгө оруулагчдыг эрсдэлийг хамгаалах бөгөөд даатгагдсан бондыг 7 сараас хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх,
3. Хөрөнгийн зах зээл дэх бусад санхүүгийн хэрэгслийг хэрэглэх замаар барилгын салбарын компаниудыг санхүүжүүлэх,
4. Барилгын салбарын компаниудад хөрөнгийн зах зээлийн талаарх сургалт, семинарыг зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО ХАМТРАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



Монголын хөрөнгийн биржээс хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын нэг болох хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх ажлын хүрээнд Монголын даатгагчдын холбоотой хамтран ажиллаж эхлээд байгаа билээ.

Санхүүгийн салбарын гурван гол тулгуурын хоёр нь болох үнэт цаасны салбар болон даатгалын салбар нийлээд санхүүгийн салбарын 2 орчим хувийг эзэлж буй эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд дээрх салбаруудын төлөөлөгчид хамтран ажилласнаар санхүүгийн салбар тэнцвэртэй хөгжих боломж бүрдэж, санхүүгийн салбарт чухал ахиц гаргана гэдгийг албаны хүмүүс онцолж байна.

Хамтын ажиллагааны эхлэл болгон талууд 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Санамж бичигт талууд үнэт цаасны зах зээлд санхүүгийн шинэ хэрэгсэл буюу даатгагдсан компанийн бонд нэвтрүүлэхэд хамтран ажиллах, даатгалын нөөц сангуудад төвлөрсөн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны зах зээлд оруулах, даатгалын компаниудаас IPO хийхэд МХБ-ээс мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагчид болон салбарын мэргэжлийн байгууллагууд хооронд үр дүнтэй уулзалт, семинар, сургалтыг тогтмол зохион байгуулж байх зэрэг хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг тусгажээ. Санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээний эхэнд Монголын даатгагчдын холбооны ерөнхийлөгч хатагтай Д.Чулуунцэцэг “цан” цохин Монголын хөрөнгийн биржийн 5001 дэх удаагийн арилжааг нээлээ.

Талуудын шинээр нэвтрүүлэхээр зэхэж буй “Даатгагдсан компанийн бонд” нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, компаниудын хөрөнгө босгох боломжийг нэмэгдүүлэх бол, даатгалын компаниудын даатгалын нөөц сангуудад төвлөрөөд буй 13 орчим тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөнөөс үнэт цаасны зах зээлд оруулснаар хөрөнгө оруулалтын зохистой ажиллагааг дэмжих, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарын хөгжилд чухал ач холбогдолтой юм.

"MONGOLIA BUSINESS SUMMIT 2015"-Д ОРОЛЦЛОО

Их тэнгэр цогцолборын хойморт "Монголын бизнесийн дээд хэмжээний уулзалт 2015" 6-р сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа билээ. Энэхүү арга хэмжээнд Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар үндсэн илтгэгчээр оролцож, Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, МХБ-ийн бодлого үйл ажиллагааг танилцуулж, бизнес эрхлэгчдэд МХБ-ээр дамжуулан хөрөнгө босгох боломжуудын талаар танилцуулга хийлээ.



ТАЙВАНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



2015 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Тайван улсын Тайваны Арилжаа Эрхлэгчдийн холбооны ерөнхийлөгч Хунг-Вэн Чиэн болон бусад төлөөллийн хамт хөрөнгийн биржид зочиллоо.

Уулзалтын үеэр Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал болон Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааны талаар мэдээлэл

өгч, цаашдаа хөрөнгө оруулагчдыг татах талаар хоёр тал харилцан мэдээлэл солилцов.

МОНГОЛЫН ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН МЭРГЭЖЛИЙН ИНСТИТУТИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЛАА

2015 оны 6-р сарын 25-нд Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институтийн төлөөлөл Монголын хөрөнгийн биржд айлчилж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний нөөц үнэлгээний тайланг уул уурхайн компаниудад хэрэгжүүлэх, уул уурхайн компаниудыг хөрөнгийн зах зээлд гаргах талаар санал солилцож, цаашид хамтран ажиллахаар боллоо.



Уулзалтанд Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институтийн ерөнхийлөгч Д.Дамба, гүйцэтгэх захирал Б.Оюунгэрэл, удирдах зөвлөлийн гишүүн Б.Наранбаатар нар оролцсон.

Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институт нь Ашигт малтмалын нөөцийн стандартын олон улсын хорооны /CRIRSCO/ гишүүн бөгөөд салбарын мэргэжилтэнгүүдийн ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх, олон улсын заавар журмыг үндэсний онцлогт тохируулан боловсруулж хэрэгжүүлэх зорилготой төрийн бус байгууллага юм.

Д.АНГАР: ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛЭЭС 10 ИХ НАЯД ТӨГРӨГ БОСГОХ БОЛОМЖТОЙ

-Сүүлийн үед компаниуд бонд гаргахад нээлттэй, даатгалын компаниудтай хамтраад ажиллавал дажгүй мөнгө босгох боломжтой гэж иргэд ярьдаг боллоо. Компаниуд бонд гаргах боломж жинхэнэ утгаараа нээгдсэн үү?

-Компанийн бонд гэж иргэд ярихаар бидэнд шинэ юм шиг сонсогдоод байна л даа. Уг нь хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх хамгийн эхний бүтээгдэхүүн. Хөрөнгийн зах зээлийн үүсэл өөрөөсөө бондоос улбаатай. Анх Засгийн газрын бонд гаргаж байсан. Үүнийхээ дараагаар компаниуд нь бонд гаргасан. Бондын дараа хувьцааны арилжаа жинхэнэ утгаараа үүсдэг. Гэтэл бид 1990 онд ягаан, цэнхэр тасалбар гээд баахан хиймэл хувьцаа үүсгэж хүн бүрт өгсөн. Сонгодог утгаараа хөрөнгийн зах зээл, хөрөнгийн бирж гэж үзэхэд хүндрэлтэй л дээ. Тийм учраас бид өнөөдрийг хүртэл бонд гэдэг асуудлыг ойлгохгүй яваад байна. Бонд гэдэг бол хүн төрөлхтний урт хугацааны хэрэглээг хангаад ирсэн зүйл. Ер нь аж ахуйн нэгжүүд урт хугацаатай, бүтээн байгуулалтын, хөгжлийн төслүүдээ бондоор л санхүүжүүлдэг. Тоглоомын дүрэм нь тийм. Яагаад гэвэл урт хугацаатай, бага хүүтэй санхүүжилтийг бондоор л босгож болдог. Гэтэл өнөөдөр эдийн засаг санхүүгийн хувьд маш том гажуудалтай болчихсон. 1990 онд үүссэн гажуудал өнөөдрийг хүртэл засагдахгүй яваад ирсэн. Тэр нь эдийн засгаа барьчихаад л байна л даа. Банкны систем дангаараа нийт санхүүгийн салбарын 95 хувийг эзэмшиж байгаа.

-Ингэхэд зүй жамаараа бол банкны салбар санхүүгийн салбарын хичнээн хувийг эзлэх учиртай вэ?



-Солонгорсон эдийн засгийн хувьд санхүүгийн салбарын 40 хувь нь хөрөнгийн зах зээл, 30 хувь нь банк, 30 хувь нь банк бус бусад салбар тодруулбал даатгал, хөрөнгө оруулалтын зөвлөх гэх мэтээр явдаг. Гэтэл манайд 30 байх ёстой хувь нь 95 болчихоор санхүүгийн том гажуудал болчихдог. Энэ рүүгээ бид компаниудаа чихэж оруулаад байгаа юм. Зөвхөн банкнаас зээл авахаас аргагүй гэчихдэг. Нэгэнт хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүү нь байхгүй зах зээлд банкинд хандахаас аргагүй болчихож байна л даа. Банкнаас авдаг зээл нь богино хугацаатай, өндөр хүүтэй. Дунджаар 2-3 жил, хүү нь 20-30 хувь. Ийм зээл рүү иргэд, аж ахуйн нэгжээ чихээд оруулчихаар улсаараа гажуудчихаад байна. Үүнийг засах ганц

арга нь хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх. Хөрөнгийн биржийн удирдлага мундагтаа хийгээд байгаа юм биш л дээ. Угаасаа дэлхий нийтийн жишиг. Санхүүгийн салбарын тулгын гурван чулуу нь хөрөнгийн зах зээл, даатгал, банк. Гэтэл манайх банк гэдэг нэг шон дээр дэнжигнэж байгаа. Унавал улсаа доош нь унагах эрсдэлтэй. Тэгэхээр санхүүгийн салбарыг лебаралчлаад хувьцааг нь зөв тогтоох ёстой. Үүний тулд хөрөнгийн зах зээл нь хөгжих ёстой. Аж ахуйн нэгжүүд маань зөвхөн банкны зээлээр биш, 200, 300 жилийн өмнөөс хэрэглэж ирсэн, нотлогдсон санхүүгийн хэрэгслийг ашиглах ёстой. Энэ нь компанийн бонд.

-Компанийн бондыг хөрөнгийн зах зээл дээр яаж гаргах вэ гэдэг мөн л шинэ асуудал гэж бодож байна?

-Бонд гаргана гэж хүнээс мөнгийг нь зээлж байгаатай л агаар нэг. Таны гаргасан бондыг би худалдаж аваад оронд нь мөнгөө өгнө. Та миний өгсөн мөнгийг аривжуулаад буцааж өгөх учиртай. Тэгэхээр би таны зээлжих зэрэглэлийг тогтооно гэсэн үг. Олон улсад зээлжих зэрэглэлийн компаниуд үүсчихсэн. “Стандарт энд пүүрс”, “Мүүдис”, “Фитч” гээд гурван том компани бий. Тэд бонд гаргаж буй компаниудыг судлаад зэрэглэл тогтоогоод өгчихдөг юм. AAA, AA, A ч гэдэг юм уу, BBB, BB, B гэх мэтээр. Хөрөнгө оруулагчид таныг судлах шаардлагагүйгээр эдний үнэлгээг хардаг. AAA бол эрсдэлгүй юм байна, таван хувьтай өгчихье гэнэ. C ангилалтай бол эрсдэлтэй юм байна, 10 хувиар мөнгө зээлье гэсэн шийдвэр гаргачихдаг. Ингэж хүүгээ тогтоодог. Манай улсын хувьд санхүүгийн систем нь хөгжөөгүй учраас зээлжих зэрэглэл тогтоодог функц нь дотооддоо байхгүй. Гандны том байгууллагуудын хөлсийг дотоодын компаниуд нь дийлдэггүй. Засгийн газрын хувьд тэдний

зэрэглэлээр тогтоолгочихож байна л даа. Тийм учраас бид хөрөнгийн зах зээлийнхээ хөгжлийн шаттай уялдуулаад орлуулах бүтээгдэхүүн гаргаж ирсэн. Даатгалтай уяаад өгчихөж байгаа юм. Хөрөнгө оруулагч бүр санхүүч байх албагүй. Хэрэглээнээсээ илүү гарсан мөнгөөр бонд гаргаж хүүг нь авч болно. Зээлжих зэрэглэл байхгүй учраас тэрийг нь даатгалын компаниудаар оруулаад даатгаад өгчихөж байгаа хэрэг л дээ. Энэ хүн мөнгөө төлж чадахгүй бол даатгалын компани өмнөөс нь үндсэн болон хүүгийн төлбөрийг хийнэ гэхчхэж байгаа юм.

-Тэгэхээр даатгалын компаниуд зээлжих зэрэглэл тогтоодог компаниудын үүргийг өөр дээрээ авчихаж байгаа юм байна. Ингэж ойлгож болох уу?

-Зарим талаараа тэгж ойлгож болно. Бид өнгөрсөн долоо хоногт Даатгалын холбоотой хамтраад даатгагдсан бонд гэсэн асуудлыг ярьсан. Энэ бол зөвхөн гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

-Компаниуд хэр сонирхож байна?

-Аж ахуйн нэгжүүдийн хувьд сонирхол өндөр байна. Ямар бүтээгдэхүүн гараад ирэв, бид яаж оролцвол боломжтой вэ гэж асууж эхэллээ.

- Тэгээд хамгийн боломжтой салбар нь тодорхой болж байна уу?

-Хамгийн боломжтой нь барилгын салбар байна. Өнөөдөр (өчигдөр) гэхэд л Барилга хот байгуулалтын сайдтай санамж бичигт гарын үсэг зурлаа. Барилгын компаниудын хувьд заавал даатгалтай байх албагүй. Үндэсний хэмжээний хүлээн зөвшөөрөгдсөн компани бол даатгал төлж нэг, хоёр хувийн даатгалын зардал гаргахгүй байж болно. Хөрөнгө оруулагч нь хүлээн зөвшөөрч байвал асуудалгүй. Барилгын компаниудын бонд гаргах асуудлыг

нээгээд өгчихөж байгаа хэрэг.

-Ойрын хугацаанд бонд гаргахаар компани байна уу?

-Ойрын хугацаанд нэг компани бонд гаргах нь тодорхой болсон. Энэ жилдээ багтаж дахиад гурваас таван компани бонд гаргах асуудал яригдаж байна. Гэхдээ ганц барилга биш л дээ.

-Хамгийн ихдээ хэдэн төгрөгийн бонд гаргах боломж компаниудад байна?

-Арав орчим тэрбум төгрөгөөр үнэлэгдэх бонд гаргахаар ярьж буй кампани ч байна. Дажгүй явчихаар ажил гэж харагдаж байгаа. Яагаад гэхээр хөрөнгийн зах зээл дээр боломж бий.

- Хөрөнгийн зах зээлээс нийт хичнээн төгрөг босгох боломж бий гэж та харж байгаа вэ?

-Хөрөнгийн зах зээл дэх нийт эх үүсвэрийг 10 их наяд төгрөг гэж харж байгаа. Төсөлрүү оролцох бололцоотой 3-5 их наяд төгрөгийн боломж бий. Үүнийг татах өртөг нь хэд байх вэ гэсэн асуудал гарна. Санхүүжилтийн дундаж өртөг нь 12 хувийн хүүтэй. Энэ өртөг банкаар дамжихаар өөр. Эцсийн хэрэглэгч хүртэл ашиг нь нэмэгдээд 25-30 болчихож байгаа юм. Бонд гаргавал банкаар дамжихгүй. 12 хувийн эх үүсвэртэй шууд холбогддог. Дунд нь брокерийн шимтгэл гээд 0.01 хувь, даатгалын хураамж нэг хувь ч юм уу бий. Гэхдээ л 13 хувиас хэтрэхгүй. Тэгэхээр компаниудаар 13 хувийн хүүтэй, богино, дунд, урт хугацаатай бонд гаргах боломж нь нээлттэй гэсэн үг. Энэ нь бас нотлогдсон. Саяхан Засгийн газрын үнэт цаасны арилжаа маш амжилттай болсон. Засгийн газрын үнэт цаасны арилжаа аль ч улсын хувьд эрсдэлгүй учраас эрэлт өндөртэй байдаг. Гэтэл өнгөрсөн жил намайг

ажлаа авахад зарагддаггүй, дөрөвхөн банк авч ядсан, хүү нь байнга өссөн дүр зурагтай байсан. Хөрөнгийн бирж арилжаанд ороод ирэхээр эрэлт нь нэмэгдчихэж байгаа юм. Зохиомлоор өсгөөд байгаа болов уу гэсэн сэрдэлт бий. Засгийн газрын үнэт цаас өнгөрсөн арваннэгдүгээр сард орж ирсэн. Тэр цагаас хойш хүү тогтмол буурсан. Бодитойгоор хоёр хувиар буурчихаад байна. Цаашдаа ч буурна гэсэн үг.

-Анх 16 хувиар гарсан гэхээр 14 хувь болсон гэсэн үг үү?

-Тийм. Уг нь намайг анх ажил авахад есөн хувь байсан юм. Эргээд есөн хувь руу орох боломжтой. Дөрөвхөн сарын дотор 16 хувь болж өсч байсан. Иргэд компаниудад шууд хамааралгүй учраас тоогоогүй. Гэтэл цаад утгаараа аж ахуйн нэгжүүдийн бонд гаргах боломжийг хаачихаж байгаа юм.

-Засгийн газрын үнэт цаасны хувь ес рүү ороход ямар боломж нээгдэх вэ?

-Компаниуд 11 юмуу 12 хувиар санхүүжилт босгох боломж нээгдэж байгаа юм.

-Засгийн газрын үнэт цаасны хүү хэзээ ингэж буурах боломжтой вэ?

-Мэдээж хүчээр бууруулна гэж байхгүй. Зах зээлийнхээ эрэлт нийлүүлэлтийн зарчмаар буурна. Өмнө нь дөрөвхөн банк аваад ямар ч хяналтгүй өсч байсан. Одоо хүн бүр орох эрхтэй болсон. Мэдээлэл нь ил тод. Тэгэхээр шууд өсгөх боломжгүй болсон. Тийм учраас буураад байна л даа. Сүүлдээ буурахаас гадна бонд олдохоо болилоо.

-Тэгэхээр Засгийн газрын бондын арилжаа эрэлттэй болжээ. Сүүлийн арилжаа гэхэд ямар байв?

-Сүүлийн дөрөв, таван арилжаан дээр Хөрөнгийн бирж дээр 200 тэрбум төгрөгийн захиалга ирлээ. 70 тэрбумд нь л нийлүүлэлт хийлээ. Тэгэхээр 130-150 тэрбум төгрөгийн эрэлт байна. Энэ хэмжээний бэлэн мөнгө байгаа гэсэн үг.

-Цаашдаа хичнээн төгрөгийн эрэлт байна гэж харж байгаа вэ?

-Таван их наяд.

-Тэгэхээр Засгийн газрын бонд эрэлтээ дийлэхгүй байгаа юм чинь компани бонд гаргавал зах зээл байгаа гэсэн үг үү?

-Зах зээл шингээгээд авчихна.

-Манай даатгалын компаниуд баталгаа өгч байна гэхээр нэлээд боломжийн болжээ дээ?

-Даатгалын компаниудын хувьд хөгжлийн шат нь Хөрөнгийн биржтэйгээ адил шатанд яваа. Банк 95 хувиар давамгайлсан. Үлдсэн 5 хувийг нь бид хувааж байгаа. Мэдээж шууд том хөрөнгө оруулалт боломжгүй. Эхний ээлжинд 500 сая, нэг тэрбум гээд үе шаттайгаар нэмэгдэнэ. Даатгалтай 10 тэрбумын бонд гаргах болоогүй. Тэрбумаар эхэлж таарна. Бонд эргэж төлөгдөөд итгэл үүсвэл 80 хувьд нь даатгаад явах боломжтой. Ингээд бодохоор зах зээл дээр зөвхөн бондоор 500 тэрбумаас нэг их наяд төгрөгийн бонд гаргах өргөн боломж бий гэж харж байгаа. Цаашлаад таван их наяд. Санхүүгийн эх үүсвэр банкны хадгаламжийн хүүтэй тэнцэнэ. Одоо банкны хадгаламжийн хүү дунджаар 12 хувь байгаа. Цаашдаа буурна.

-Яагаад буурна гэж?

-Банкууд 12-15 хувийн хүүг өгч чадаж байгаа нь цаанаа учиртай. Нөгөө талдаа Засгийн газраас 16 хувийн хүүг авчихаж

байгаа юм. Засгийн газрын хүү буурвал хадгаламжийн хүүгээ өгч чадахаа болино. Хадгаламжийн хүү нь өндөр байгаа нь нэг талдаа иргэдэд ашигтай. Нөгөө талдаа эдийн засгаа боомилж байгаа хэрэг. Хожиж байгаа нь ганцхан банк. Засгийн газрын үнэт цаасны хүү боломжит хэмжээндээ очвол банкууд хадгаламжийнхаа хүүг бууруулна. Ингэснээр аж ахуйн нэгжийн санхүүжилт авах өртөг нь буурч байгаа юм.

-Нээрээ л компаниудын толгойн өвчин нь санхүүжилт шүү?

-Яг тийм, санхүүжилт нь олдлоо гэхэд өндөр хүүтэй, богино хугацаатай. Бөөн юм болж зээл авдаг. Эхний жилээсээ л хүүгийн төлбөр, хоёр дахь жилээс үндсэн төлбөр нэхэгдэж, гурав дахь жилээс төлж чадахаа больдог. Өнөөдөр гэхэд л банкны системд муу зээл толгойн өвчин болж эхэлж байна. Аж ахуйн нэгж, эдийн засаг муудаа биш сайн аж ахуйн нэгжүүдийг муу зээлрүү шахаад оруулчихаар хэцүү байдал үүсчихэж байгаа юм.

- Мөнгөтэй иргэдийн хувьд найдвартай гэсэн компанийхаа бондыг худалдаж авах боломтой болж байгаа юм байна?

-Тэгэх бүрэн боломжтой. Тодорхой хугацааны дараа хүүг нь компани төлнө гэсэн үг. Хадгаламжтай адилхан. Засгийн газрын зээл дунджаар 15 хувийн хүүтэй байгаа. Компани хоёр хувийн нэмэлт хүү төлж байж таныг татна. Засгийн газрын өнөөдрийн хүү хөөсөрсөн, байж боломгүй хүү. Засгийн газрын хүү нь нэг оронтой тоо буюу есөн хувьруу орж байж аж ахуйн нэгж хоёр хувиа нэмээд 11 хувиар бонд гаргах боломжтой. Одоо бол Засгийн газар 15, аж ахуйн нэгж 17 хувиар гаргаж болно. Цаашдаа ч жамаараа аль аль нь буураад явна.

Эх сурвалж: Өдрийн сонин 2015.06.25
Д.Баасансүрэн

ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДАД ЗОРИУЛСАН “ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ” СЭДЭВТ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчны шинэчлэл” сэдэвт семинар Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудад зориулан 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдөр хөрөнгийн биржид амжилттай, үр дүнтэй явагдлаа.

Уг семинарт СЗХ, ҮЦТТТХТ-ийн удирдлагууд болон МХБ-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар нар зохицуулалтын орчны шинэчлэлийн талаар танилцуулж, үнэт цаасны компаниуд болон арилжаа эрхлэгчдийн холбоотой харилцан санал солилцлоо.

Түүнчлэн зах зээлд оролцогч байгууллагууд тус бүр дээр үүсэж буй асуудлуудыг тусгайлан хэлэлцсэн бөгөөд МХБ-ийн үйл ажиллагаанд ямар нэгэн асуудалгүй гэдэгт санал нэгдэж, МХБ-ийн зүгээс Back office-ийн холболтын хураамжгүй болгож зах зээлд оролцогчдоо дэмжихээр боллоо.

Мөн МХБ, ҮЦТТТХТ, үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон үнэт цаасны компаниуд өөрсдийн үүсээд буй асуудлыг 9 дүгээр сарын 1-ний дотор СЗХ-оор шийдвэрлүүлэхээр ажлын хэсэг байгуулан ажиллаж хоорондын уялдаа холбоогоо сайжруулахаар боллоо.



ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ЗГҮЦ-ИЙГ ХУДАЛДАН АВАХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛЛЭЭ



БНСУ-ын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг манлайлан ирсэн БНСУ-ын шилдэг үнэт цаасны компани болох KDB Дэу Секьюритис ХХК-ийн төлөөлөгчид өнөөдөр буюу 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн биржид зочиллоо. Энэ өдөр Монголын хөрөнгийн биржийн 5007 дахь удаагийн үнэт цаасны арилжаа тохиож нээлтийг KDB Дэу Секьюритис ХХК-ийн Тэргүүн дэд захирал Ли Сам Гю “Цан” цохин эхлүүллээ.

Тус компанийн Монгол дахь салбар нь 2013 оны 6 сард байгуулагдсанаас хойш гадаадын зах зээл дээрх арилжигдаж буй Монгол улсын бондын арилжаа (Одоог хүртэл 5 сая долларын арилжаа), Монгол улсын “хадгаламж болон долларын бонд”-д суурилсан санхүүгийн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээл (өнөөг хүртэл 45 сая доллар орчим арилжаа) дээр арилжаах үйл ажиллагааг Монголд анх удаа нэвтрүүлсэн зэргээр Монгол улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн төлөө хувь нэмрээ оруулж буй бөгөөд ялангуяа ЗГҮЦ-ны арилжааг идэвхижүүлэх талаар хөрөнгийн бирж болон холбогдох байгууллагуудтай идэвхи чармайлттай харилцан ажиллаж, 2014 оны 11 сард ЗГҮЦ-ны арилжаа хөрөнгийн биржээр арилжигдаж эхэлснээс хойш Солонгосын хуулийн этгээдүүд болон хувь хүмүүсийг идэвхитэй зуучилж байна. Цаашид ч Солонгосын хөрөнгө оруулагчид ЗГҮЦ-нд хөрөнгө оруулах сонирхол их байгааг онцлоод, Монголын хөрөнгийн биржид илүү их хөрөнгө оруулагчдыг зуучлах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 6 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 26-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	3,049,949
Нийт үнийн дүн /төг/	93,901,267,552.40
Хэлцлийн тоо	1524
Арилжигдсан үнэт цаасны тоо	69
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,408,502,503,115


ТОП-20 индекс

Хаалт	15,023.81
Өөрчлөлт /%/	17.77

MSE ALL индекс

Хаалт	1,025.89
Өөрчлөлт /%/	11.31

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	N	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	ETR	Э-ТРАНС ЛОЖ ИСТИКС	583,400	1	BDS	БИ ДИ СЕК	447,735,650
2	MRX	МЕРЕКС	345,613	2	APU	АПУ	225,449,644
3	RMC	РЕМИКОН	325,300	3	КЕК	МОНГОЛ КЕРАМИК	97,403,975
4	BDS	БИ ДИ СЕК	254,835	4	SOI	ЕВРОФЕАЗИА	97,349,000
5	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	110,060	5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	80,439,112

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	HGN	ХӨХ ГАН	142.00	102.86	
2	SHG	ШАРЫН ГОЛ	7,310.00	82.70	
3	SHV	ШИВЭЭ ОВОО	5,500.00	57.14	
4	BAN	БАГАНУУР	3,200.00	56.02	
5	ADL	АДУУН ЧУЛУУН	1,850.00	31.67	

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	CHR	УВС ЧАЦАРГАНА	1,000.00	-52.94	
2	IBA	ИХ БАРИЛГА	4,800.00	-23.81	
3	SOR	СОР	1,700.00	-17.48	
4	MNS	МОННООС	3,240.00	-14.74	
5	HSX	ХИШИГ УУЛ	650.00	-14.47	

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-12-310	300,000	29,014,500,000	96,715	12	14.758
2	ЗГХБ-Б-28-312	150,000	13,880,400,000	92,536	28	15.020
3	ЗГХБ-Б-12-314	300,000	29,019,900,000	96,733	12	14.674
4	ЗГЭБ-Б-52-315	100,000	10,000,000,000	100,000	52	15.473
5	ЗГХБ-Б-12-317	99,990	9,677,932,110	96,789	12	14.415

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлийн ханш
1	Z GEB-BL-10/07/15-A0027-0	3,961	388,534,490	98,090	98,090	98,090
2	Z GEB-BL-28/07/15-A0031-0	3,036	303,296,400	99,900	98,860	98,890